



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг; Булган сүм, Булган аймаг, 63082  
Утас/Факс:7034-2580  
E-mail:bulgan@audit.gov.mn

## БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ СҮМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД

2024. 08. 19 № 688  
татай ны № т

# Сонгуулийн мэрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Х.Ганхуягийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

## Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

## Сонгуулийн мэрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эзлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аudit MNS 6817 - 1 : 2020 Төрийн аudit. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аudit. Нийцлийн аuditын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аudit. Нийцлийн аudit стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай аudit түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн 2025-2026 оны Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, төсөөллийн тухай хууль, төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021393

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн Х.Ганхуяг Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын дугаар зүйлийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн Х.Ганхуягийн мөрийн хөтөлбөр (...1...хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн Х.Ганхуягт

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭ

2024 оны Баян-Агт сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд  
бие даан нэр дэвшигч Хасбаатарын Ганхуяг миний  
Мөрийн хөтөлбөр

1. Сумын төвийн замыг иргэд, аж ахуйн нэгжүүдтэй хамтран орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр жил бүр засварлах ажлыг зохион байгуулах
2. Золбин нохой устгалыг жил бүр 2 удаа аюул учруулахаас нь өмнө зохион байгуулах
3. Иргэдийн хурлаар баталсан журмыг хэрэгжүүлж малтай айлуудыг шинэ бүс рүү нүүлгэх ажлыг дэмжин оролцуулах
4. Айл өрхийн хогийн сар тутам ачиж хэвшүүлэх
5. Нийтийн эзэмшлийн болон төрийн байгууллагуудын гадна тохижилт, сандал ширээ, саравч зэргийг сар бүр эргэж засаж сэлбүүлж байхад анхаарал хандуулж хамтран ажиллах
6. Автомат худгийн хог, мөс зэргийг хуваарь гарган тогтмол цэвэрлэж аюулгүй байдлыг хангзуулахад сумын удирдлагад уламжилж дэмжин ажиллах
7. Хогийн цэгийн хогийг түрж хумих, гадуур асгах тэлэх явдалд идэвхитэн байгаль хамгаалагчтай болон нутгийн иргэдтэй хамтран хяналт тавьж ажиллах
8. Хог шатаах байдлыг таслан зогсооход байгаль хамгаалагч, байгаль орчны байцаагч нарт шаардлага тавьж ажиллах

Х.Ганхуяг

Хүрэмт багийн иргэн

9913-0905